



Дорнод аймгийн орон нутгийн 2021 оны төсвийн төсөлд өгөх санал, дүгнэлт

*Төрийн аудитын байгууллагын эрх зүйн орчин,
стандартын шинэтгэлийн жил-2020 он*

**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	2
ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛИЙН ТОВЬЁГ	3
ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	4-5
БҮЛЭГ 1. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН ХЯЗГААР	6-8
БҮЛЭГ 2.ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ	8-9
БҮЛЭГ 3.ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ	9-10
БҮЛЭГ 4. ТЕЗ-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН, ЗОРИЛТОТ ТҮВШИН	
4.1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	10-11
4.2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БУС ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР	12-13
4.3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН	13-19
БҮЛЭГ 5. САНГИЙН ЗАРДЛУУД	
5.1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ ЗАРДАЛ	20-24
5.2. АВТО ЗАМЫН САН	24
5.3. ХАЛАМЖИЙН САН	25
ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	25
ДҮГНЭЛТ	26
2021 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ	26
АЙМГИЙН ИТХ-ЫН ХАРИУ	27

Товчилсон үгийн тайлбар

ЗГ	Засгийн газар
СЯ	Сангийн яам
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
МУЗЗНДНТУТХ	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
СХДАА	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ОНОТХҮ	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ААН	Аж ахуйн нэгж
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНОТХҮ	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ
БОХНСЗ	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал
ХОБ	Хөрөнгө оруулалтын бус
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
БХС	Байгаль хамгаалах сан
АЗС	Авто замын сан

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн 2021 оны төсөв дэх суурь орлогын харьцуулалт	6
Хүснэгт 2	Аймгийн 2021 оны төсвийн төслийг суурь хязгаартай харьцуулсан харьцуулалт	6-7
Хүснэгт 3	Аймгийн 2020, 2021 оны төсвийн орлогын хязгаар	8
Хүснэгт 4	Хасах саналтай төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүд-ХОБ төсөл, хөтөлбөр	12-13
Хүснэгт 5	Үр дүнг сайжруулах төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүд-ХОБ төсөл, хөтөлбөр	13
Хүснэгт 6	ОНХС-гаар хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй төсөл, арга хэмжээ	14-15
Хүснэгт 7	Хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлт гаргаагүй төсөл арга хэмжээ /ОНХС/	15-16
Хүснэгт 8	Зураг, төсөвгүй төсөл арга хэмжээ /ОНХС/	16
Хүснэгт 9	Хэмнэлтгүй, үр ашиг тодорхойгүй, тэвчиж болох төсөл, арга хэмжээ	16-17
Хүснэгт 10	Үр ашгийг сайжруулах төсөл, арга хэмжээ /ОНХС/	17
Хүснэгт 11	Хууль, журамд нийцэхгүй арга хэмжээ	18-19
Хүснэгт 12	Төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх	19
Хүснэгт 13	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн хувь, хэмжээ	20
Хүснэгт 14	Орлого /БХНСЗ/	20
Хүснэгт 15	Зарлага /БХНСЗ/	20
Хүснэгт 16	Ажлын төсөв, тооцоо, ажлын даалгавар, удирдамж, төлөвлөгөө нь хийгдээгүй төсөл, арга хэмжээнүүд /БХНСЗ/	22
Хүснэгт 17	Ажлын төсөв, төлөвлөгөө, даалгавар, техникийн тодорхойлолтыг /БХНСЗ/батлуулаагүй, төсвийн тооцооллын задаргаа нь бүрэн хийгдээгүй төсөл, арга хэмжээнүүд /БХНСЗ/	23-24

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Хандивын орлого, 2018-2020 оны харьцуулалт	10
Дүрслэл 2	ОНХС-гийн төсвийн төсөл	15
Дүрслэл 3	Төсөл арга хэмжээний төлөвлөлт, БХНСЗ	23

Зорилт, хамарсан хүрээ, арга зүйн талаарх мэдэгдэл

Үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь “Монгол Улсын Засгийн газар /цаашид “Засгийн газар” гэх/-аас Монгол Улсын Их Хурал /цаашид “Улсын Их Хурал” гэх/-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын жилийн төсвийн төсөл, түүнчлэн аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөлд **төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж**, Улсын Их Хурал болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх” гэж заасны дагуу Дорнод аймгийн 2021 оны төсвийн төсөлд өгөх санал, дүгнэлтийг 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс 12 дугаар сарын 03-ны өдөр хүртэлх хугацаанд хийв.

Зорилт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн өргөн мэдүүлсэн орон нутгийн 2021 оны төсвийн төсөл нь холбогдох шалгуур үзүүлэлтүүдэд нийцсэн эсэхийг хангахад зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр санал, дүгнэлтийг гүйцэтгэлээ. Үүнд:

- Төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх
- Төсвийн зарлагыг бууруулах
- Төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх

Хамрах хүрээ

Дорнод аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын холбогдох хэлтсүүдийг хамрууллаа.

Аймгийн Засаг даргаас аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн 2021 оны жилийн төсвийн төсөл, холбогдох нотлох баримтууд болон тооцоо, судалгааг хамрууллаа.

Шалгуур үзүүлэлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн өргөн мэдүүлсэн орон нутгийн 2021 оны төсвийн төсөл нь дараах шалгуур үзүүлэлтүүдэд нийцсэн эсэхийг авч үзлээ. Тухайлбал:

1. Төсвийн тухай хууль
2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2021 оны төсвийн төсөл, 2022-2023 оны төсвийн төсөөлөл бэлтгэх удирдамж
3. МУЗЗНДНТУТХ
4. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
5. Газрын тухай хуулийн
6. Тариалангийн тухай хууль
7. Нийгмийн халамжийн тухай хууль
8. Сангийн Сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”
9. Сангийн Сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”
10. Сангийн Сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”
11. Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоол “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”
12. Холбогдох бусад хууль, журам, заавар

**Холбогдох
мэдээлэл**

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2021 оны төсвийн төсөл, 2022-2023 оны төсвийн төсөөлөл бэлтгэх удирдамжид төсвийн зарлагын удирдлагын шинэчлэлийн хүрээнд **үр дүн, нотолгоонд суурилсан, оновчтой, үр ашигтай төлөвлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх, төсвийн зарлагын шинэчлэлийг үргэлжлүүлж, төсвийн урсгал зардлыг хэмнэх, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой байхаар төлөвлөлтийг хийхээр заасан.**

Төсвийн удирдлагын үндсэн зарчмууд нь төрийн шийдвэр гаргах болон хянах үе шатуудад гарч болзошгүй эрсдэлийг тодорхой хэмжээнд бууруулах, эсвэл урьдчилан сэргийлэх, чанарыг сайжруулахад чиглэгддэг.

Ирэх жилд Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын эрсдэлийг даван туулахад чиглэсэн төрийн урсгал зардлын оновчтой хуваарилалт хийж, тэвчиж болох зардлыг бууруулах, жилийн урсгал төсвийн хязгаарыг тогтоосон байна.

Төсвийн тухай хуулийн 8.5.1 дэх “аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх” гэсэн заалт байхад төсвийн төслийг холбогдох тооцоо судалгаа, баримтуудыг хавсарган хугацаанд нь ирүүлээгүй асуудал давтан гарч холбогдох хэлтэс, байгууллага, албан тушаалтнуудаас тооцоо судалгааг гаргуулан авсан.

**Гүйцэтгэсэн
бүрэлдэхүүн,
хугацаа**

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, бүх аудиторууд хуваарийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Талбарын ажлыг 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлүүлж, санал, дүгнэлтийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга М.Энхтөрд 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдөр хүргүүллээ.

БҮЛЭГ 1. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН ХЯЗГААР

Төсвийн тухай хуулийн 31.1.3-т зааснаар төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн жилийн төсвийн төслийг Сангийн яамнаас хянан ирүүлсэн хязгаарт багтаан боловсруулахаар заасан.

Төсвийн тухай хуулийн 4.1.8-д жилийн төсвийн хязгаарыг тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод, зарлагын дээд хэмжээ бөгөөд жилийн суурь орлогыг 21.8 тэрбум төгрөгөөр хянасныг, 23.8 тэрбум төгрөг болгож, 6.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн төсөлд тусган ирүүлсэн байна.

1. Аймгийн 2021 оны төсвийн төсөл дэх суурь орлогыг Сангийн яамны баталсан хязгаартай харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт №1.

“Аймгийн 2021 оны төсөв дэх суурь орлогын харьцуулалт” /мян.төг/

№	Орлогын нэр төрөл	СЯ хянасан тоо	2021 оны төсөв	СЯ хянасан дүнгийн зөрүү
1	НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	21,886,000.00	23,814,990.60	1,928,990.60
2	ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО	21,886,000.00	23,814,990.60	1,928,990.60
3	ТАТВАРЫН ОРЛОГО	20,642,000.00	22,460,990.60	1,818,990.60
3	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,244,000.00	1,354,000.00	110,000.00

Дээрх орлогоос татварын орлогыг 6.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхдээ газрын дуудлага худалдааны орлогыг 1.9 тэрбум төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 0.1 тэрбум, татварын бус орлого болох хандив тусламжийн орлогыг 4.1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэхээр тооцсон байна.

2. Аймгийн 2021 оны төсвийн төслийг Сангийн яамны баталсан суурь хязгаартай харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт №2. “Аймгийн 2021 оны төсвийн төслийг суурь хязгаартай харьцуулсан харьцуулалт”

/мян.төг/

№	Нийт зарлага	СЯ хянасан дүн /анх/	2021 оны төсөв	СЯ хянасан зөрүү	Өөрчлөлтийн хувь
1	Аймгийн ИТХ	195,958.80	268,669.00	72,710.20	15.73
2	аймгийн ЗДТГ	1,653,108.80	1,867,092.40	213,983.60	12.94
3	Сумдын ИТХ	865,614.50	992,772.50	127,158.00	14.69
4	Сумдын ЗДТГ	5,526,138.40	6,289,174.20	763,035.80	13.81
5	Орон нутгийн өмч	164,473.80	203,853.80	39,380.00	23.94
6	Санхүү хяналт аудит	146,830.70	220,231.30	73,400.60	49.99
7	сум дундын ойн анги	62,030.90	79,649.90	17,619.00	28.40
8	Ахмадын хороо	25,468.70	25,468.70	-	-
9	ахмадын чөлөөт цагийн төв	42,107.80	42,107.80	-	-
10	Хот тохижуулахын зардал	743,203.50	1,270,878.80	527,675.30	71.00

Дорнод аймгийн 2021 оны төсвийн төсөлд өгөх санал, дүгнэлт

11	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ	1,035,500.00	1,035,500.00	0.00	0.00
12	БОАЖГ	466,161.90	444,849.80	(21,312.1)	(4.57)
13	Хотын нийтийн тээвэр	66,000.00	165,000.00	99,000.00	150.00
14	Мал эмнэлгийн үйлчилгээ	345,815.50	345,815.50	-	-
15	Халамжийн сан	182,617.50	182,617.50	0.00	0.31
16	Автозамын сан	333,000.00	333,000.00	-	-
17	Ус хангамжийн татаас	64,000.00	64,000.00	-	-
18	Агаарын бохирдол	10,000.00	10,000.00	-	-
19	ЕБС, СӨБ-ийн тогтмол зардал	2,228,821.80	2,228,821.80	-	-
20	Соёл спортын ТШЗ-ийн тогтмол зардал	1,133,017.80	1,242,551.70	109,533.90	9.67
21	Музей	404,759.50	426,832.70	22,073.20	5.45
22	Хөгжимт драмын театр	1,104,561.50	1,104,561.50	-	-
23	Номын сан	253,062.40	253,062.40	-	-
24	Хүүхэд хамгааллын ТШЗ-ийн тогтмол зардал	14,617.10	14,617.10	-	-
25	Сумдын эрүүл мэндийн төв	246,264.90	246,264.90	-	-
26	Газрын харилцаа барилга ховь байгуулалтын газрын тогтмол зардал	23,836.30	23,836.30	-	-
	Нийт дүн	17,337,242.10	19,381,229.60	2,043,987.50	11.51

“Аймгийн 2021 оны төсвийн төсөл”-д суурь зарлагыг Сангийн яамнаас баталсан дээд хязгаараас нийт 2.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 19.3 тэрбум төгрөгөөр батлахаар төлөвлөсөн байна.

Сангийн яамны хянасан зардлын хязгаараас хэтрүүлэн зардлыг төлөвлөхөд нөлөөлсөн хүчин зүйлийг судлахад:

1. Орон тооны хязгаараас нийт 58 албан хаагчийн орон тоогоор нэмэгдүүлэн ажиллаж байгаатай холбоотой байна. Үүнээс:

- Аймгийн ЗДТГ-уудын орон тоог Сангийн яам нь ЗГ-ын тогтоолд заасан орон тоогоор баталж, нийтлэг үйлчилгээний албан хаагчдыг оруулан тооцдоггүй байна. Манай аймгийн хувьд нийтлэг үйлчилгээний албагүй ажиллаж байгаатай холбоотой гэсэн шалтгаанаар 15 орон тоо хэтэрсэн байна.
- Санхүүгийн хяналт дотоод аудитын алба 5, Орон нутгийн өмчийн газар 3 орон тоогоор нэмэгдүүлсэн хэвээр байна.
- Аймгийн ИТХ 5, Хэрлэн сумын ИТХ 4, сумдын ЗДТГ 14 орон тоо Сангийн яамны хянасан хязгаараас хэтэрсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 10.3, МУЗЗНДНТУТХ-ийн 20.3 дахь заалттай нийцэхгүй байна.

Энэ талаар Төрийн аудитын байгууллагаас 2018, 2019 оны төсвийн төслийн санал болон аймгийн 2019 оны төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар тус тус орон тооны хязгаарыг хууль, журамд нийцүүлэн бодитой төлөвлөн нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах зөвлөмж, санал өгсөн боловч одоо болтол үр дүнд хүрээгүй байна.

2. Зардлыг эдийн засгийн ангиллаар нь хянасан хязгаараас хэрхэн хэтрүүлэн төлөвлөсөн талаар судлах гэсэн боловч төсвийн төлөвлөлтийн программд зардлыг эдийн засгийн ангиллын дагуу шивээгүй байгаагаас шалтгаалан дүгнэлт гаргах боломжгүй байна.

САНАЛ:

1.Төсвийн суурь зарлагыг Сангийн яамны баталсан хязгаараас 1,996.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 31.1.3 дахь “жилийн төсвийн хязгаарт багтаасан байх” гэж заасантай нийцэхгүй байгаа тул төлөвлөлтийн үр ашгийг сайжруулах.

БҮЛЭГ 2. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ

Төсвийн тухай хуулийн 4.1.8-д зааснаар Сангийн яамнаас орлогын доод хязгаарыг хянаж ирүүлдэг.

Сангийн яам аймгийн 2021 оны төсвийн жилийн суурь орлогыг 21,886.9 сая төгрөгөөр хянасныг 23,815.0 сая төгрөг болгон 1,929.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

Аймгийн 2021 оны орлогын төлөвлөлтийг Сангийн яамны хянасан дүнтэй харьцуулбал татварын орлогын доод хязгаарыг баримтлан төлөвлөсөн байна. Харин газрын дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтын орлогыг 1,819.0 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 110.0 сая төгрөгөөр, гадаад дотоодын хандив тусламжийн орлогыг 4,139.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

Аймгийн 2020, 2021 онуудын төсвийн орлогын хязгаарыг хүснэгтээр харуулбал бодит гүйцэтгэлээр хязгаарыг Сангийн яам тогтоож өгсөн байна.

Хүснэгт №3. “Аймгийн 2020, 2021 оны төсвийн орлогын хязгаар”

/мян.төг/

ОРЛОГЫН НЭР ТЭРЭЛ	Сангийн яамны хянасан 2020 оны төсөв	Аймгийн 2020 оны батлагдсан төсөв	Сангийн яамны хянасан 2021 оны төсөв	Аймгийн 2021 оны төсвийн төсөл	Өмнөх оны төсвийн төсөлтэй харьцуулсан зөрүү	Сангийн яамны хянасан дүнгээс нэмэгдүүлэн төсөвлөсөн дүн
ОРОН НУТГИЙН НИЙТ ОРЛОГО, ТУСЛАМЖИЙН ДІН	67,741,493.2	71,171,804.5	70,632,659.6	76,725,308.4	7,991,162.8	6,092,648.8
ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО	18,601,147.6	18,598,958.9	21,886,000.0	23,814,990.6	4,221,190.6	1,928,990.6
ТАТВАРЫН ОРЛОГО	17,497,147.6	17,387,358.9	20,642,000.0	22,460,990.6	4,152,790.6	1,818,990.6
Бусад татвар	5,221,200.00	8,730,698.50	5,810,000.0	7,628,990.6	2,407,790.6	1,818,990.6
Газрын төлбөр	506,000.00	3,441,798.50	860,000.0	2,678,990.6	2,172,990.6	1,818,990.6
Дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт		2,924,798.50		1,818,990.6	1,818,990.6	1,818,990.6
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,104,000.00	1,061,600.00	1,244,000.0	1,354,000.0	68,400.0	110,000.0
Төсөвт байгууллагын өөрийн орлого	34,000.00	75,600.00	24,000.0	134,000.0	58,400.0	110,000.0
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	49,140,345.60	53,472,845.60	48,746,659.6	52,885,659.6	3,745,314.0	4,139,000.0
Гадаад, дотоодын хандив тусламж		4,332,500.00		4,139,000.0	4,139,000.0	4,139,000.0


Хандив тусламжийн орлого 2018 онд 757.5 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 257.3 сая төгрөг буюу 33.97 хувь, 2019 онд 4.2 тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс 3.0 тэрбум

төгрөг буюу 73.7 хувь, 2020 онд 4.3 тэрбум төгрөг төлөвлөгдсөн боловч өнөөдрийн байдлаар 3.6 тэрбум төгрөг буюу 83.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

2018-2020 онд ААН-үүдээс орсон хандивын орлогыг төлөвлөгөө, гүйцэтгэлээр харуулбал:

Дүрслэл 1.

“Хандивын орлого, 2018-2020 оны харьцуулалт, сая.төг”



2021 онд төлөвлөсөн хандив тусламжийн 4.1 тэрбум төгрөгөөс 219.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэх 4 ААН-тэй байгуулсан гэрээ байхгүй байна.

Нотлох баримтгүй газрын дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах орлого 1.8 тэрбум төгрөгийг төлөвлөсөн байна.

Газрын дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтыг зохион байгуулахыг Газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.10-д “газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалд хамаарах газрыг тогтоох болон нэг ангиллаас нөгөөд шилжүүлэх асуудлыг Засгийн газарт оруулан шийдвэрлүүлэх”, Тариалангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-д “Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх талаарх тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ” гэж заасан байна.

Төсвийн орлогыг баталгаагүй эх үүсвэрээс төлөвлөсөнөөс орон нутгийн удирдлагын хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах төлөвлөсөн хөтөлбөр, арга хэмжээнүүд үр дүнд хүрэхгүй байх эрсдэлтэй байна.

САНАЛ:

1. Нотлох баримтгүй, үндэслэлгүй төлөвлөсөн гадаад, дотоодын тусламжийн 219,0 сая төгрөг, газрын дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт зохион байгуулалтын 1,819.0 сая төгрөг, нийт 2,038.0 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх боломжгүй гэж үзэж байна

2. Төсвийн орлогыг тооцоо судалгаа, нотлох баримтад үндэслэн төлөвлөж байх.

БҮЛЭГ 3. ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ

1. Аймгийн Засаг дарга нь 2 орлогчтой байгаа нь МУЗЗНДНТХ-ийн 30.1.2-т "аймгийн Засаг дарга нэгээс илүүгүй, бөгөөд орлогчийг тухайн Хурлын Тэргүүлэгчидтэй зөвшилцөн томилох, чөлөөлөх" гэсэн заалтыг зөрчиж 2016-2020 оны 4 жилийн хугацаанд 2 орлогчтой ажилласан байна. Жил бүрийн төсвийн төсөлд орлогчийн тоог бууруулах санал хүргэдэг боловч төсөвт тусган ажилладаггүй. Мөн 2021 оны төсвийн төсөлд илүү ажиллаж буй 1 орлогчийн зардалд 19.9 сая төгрөгийг төсөвлөсөн байна.

2. Сумдын ЗДТГ болон Хэрлэн сумын ИТХ нь Сангийн яамнаас хянасан хязгаараас орон тоог хэтрүүлэн ажиллаж байна.

САНАЛ:

1. Аймгийн Засаг даргын илүү 1 орлогчийн зардал болох 19.9 сая төгрөгийг төсвөөс хасах.
2. Сумдын ЗДТГ, Хэрлэн сумын ИТХ-ын орон тоог хууль, журмын дагуу тооцоолж төлөвлөх.

БҮЛЭГ 4. ТЭС-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН, ЗОРИЛТОТ ТҮВШИН

4.1. ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Хөрөнгө оруулалтын хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлтийг Төсвийн тухай хууль, төсвийн төсөл бэлтгэх удирдамж, Сангийн Сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах" журам болон бусад холбогдох журам, зааварт нийцсэн эсэхийг шалгуур болгон авч үзлээ.

Хөрөнгө оруулалтын хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлттэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

1. Аймгийн 2021 оны орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт 317.0 сая төгрөгийн дараах 3 төсөл, арга хэмжээ нь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаагүй байна.

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын 1, 2, 3-р байрны засвар -55.0 сая төгрөг,
- Орон нутгийн өмчийн газар болон иргэдэд явуулын эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай автомашин -107.0 сая төгрөг,
- Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар, Халхгол сумын Засаг даргын тамгын газрын авто машины засвар, парк шинэчлэлт -155.0 сая төгрөг,

2. Нийгмийн, нэн тэргүүний ач холбогдолтой, хэрэгцээ шаардлагад тулгуурлан хөрөнгө оруулалтыг эрэмбэлээгүй, чиг үүрэгт байхгүй 411.0 сая төгрөгийн нийт 6 арга хэмжээ байна.

- Гражийн өргөтгөл /Зүүн бүсийн Онцгой байдлын газар/ -100.0 сая төгрөг
- Манлайбаатар Дамдинсүрэнгийн онголсон газрын баганыг сэргээн засварлах -15.0 сая төгрөг
- Орон нутгийн өмчийн газар болон иргэдэд явуулын эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай автомашин -107.0 сая төгрөг
- Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар, Халхгол сумын Засаг даргын тамгын газрын авто машины засвар, парк шинэчлэлт-155.0 сая төгрөг

- Монгол улсын Улаан загалмайн Дорнод аймаг дахь Үндэсний хүмүүнлэгийн байгууллагад авто машины авахад дэмжлэг -22.0 сая төгрөг
- Төрийн байгууллагын албан хэрэгцээнд шаардлагатай тоног төхөөрөмж /Стандарт хэмжил зүйн хэлтэс/ -12.0 сая төгрөг

3. Орон нутгийн төсвөөр улсын төсөвт байгууллагуудын автомашин худалдан авах болон засвар, тоног төхөөрөмж авах, орон нутгийн байгууллагын урсгал зардалд 174.0 сая төгрөгийг 4 төсөл арга хэмжээ төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6. “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх”, 4.1.24. “хөрөнгө оруулалт” гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг” гэсэн заалттай нийцэхгүй байна. Үр ашиггүй, тэвчиж болох төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

- Гражийн өргөтгөл /Зүүн бүсийн Онцгой байдлын газар/-100.0 сая төгрөг,
- Монгол Улсын Улаан загалмайн Дорнод аймаг дахь Үндэсний хүмүүнлэгийн байгууллагад авто машины авахад дэмжлэг- 22.0 сая төгрөг,
- Төрийн байгууллагын албан хэрэгцээнд шаардлагатай тоног төхөөрөмж /Стандарт хэмжил зүйн хэлтэс/ -12.0 сая төгрөг
- Аймгийн ЗДТГ-ын автомашины засвар үйлчилгээ-40.0 сая төгрөг

4. Шинээр барилга байгууламж, өмч бий болгох /Маршал Чойбалсангийн мэндэлсэн газарт ёслол хүндэтгэлийн цогцолбор байгуулах 47.4 сая төгрөг/ арга хэмжээнд Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2. “Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна.” Төсвийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.2. “Төсвийн төслийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэх явцад нэмж тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тухайн шатны төсвийг өргөн мэдүүлсэн этгээдээс энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар санал, дүгнэлтийг авсны үндсэн дээр тусгана.” гэж заасны дагуу дүгнэлт гаргаагүй байна.

САНАЛ:

1. Төсвийн зарлагыг бууруулах нийт 389.0 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээ

- Гражийн өргөтгөл /Зүүн бүсийн Онцгой байдлын газар/ -100.0 сая төгрөг
- Манлайбаатар Дамдинсүрэнгийн онголсон газрын баганыг сэргээн засварлах -15.0 сая төгрөг
- Орон нутгийн өмчийн газар болон иргэдэд явуулын эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай автомашин -107.0 сая төгрөг
- Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар, Халхгол сумын Засаг даргын тамгын газрын авто машины засвар, парк шинэчлэлт-155.0 сая төгрөг
- Төрийн байгууллагын албан хэрэгцээнд шаардлагатай тоног төхөөрөмж /Стандарт хэмжил зүйн хэлтэс/ -12.0 сая төгрөг

2. Төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх нийт 124.4 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээ

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын 1, 2, 3-р байрны засвар -55.0 сая төгрөг,
- Маршал Чойбалсангийн мэндэлсэн газарт ёслол хүндэтгэлийн цогцолбор байгуулах- 47.4 сая төгрөг
- Монгол улсын Улаан загалмайн Дорнод аймаг дахь Үндэсний хүмүүнлэгийн байгууллагад авто машин авахад дэмжлэг -22.0 сая төгрөг

4.2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БУС ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР

1. Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд гаргах удирдлагын зардал, ОНТХ-өөр хэрэгжүүлэх чиг үүрэгт тусгагдаагүй, тооцоо судалгаагүй, батлагдсан хөтөлбөргүй, 1 заалтыг 2 дахин оруулсан, хууль, журамд нийцээгүй зэрэг нийт 560.4 сая төгрөгийн 26 төсөл арга хэмжээг **хасах** санал оруулж байна. Үүнд:

Хүснэгт №4.

“Хасах саналтай төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүд-ХОБ төсөл, хөтөлбөр”

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөвт өртөг /сая.төг/	Тайлбар
1	3.1.2. Төрийн албан хаагчийн сургалт хөгжил, нийгмийн баталгааг дэмжих хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх /удирдлагын зардал	30,5	Хөтөлбөр ирүүлээгүй, удирдлагын зардал
2	3.1.3 "Багийн хөгжлийг дэмжих " хөтөлбөр хэрэгжүүлэх	96,0	Батлагдсан хөтөлбөргүй, урсгал зардал, орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэг биш
3	3.1.19. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагаа	7,0	Хөтөлбөр, тооцоо судалгаа ирүүлээгүй,
4	3.2.4. Зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх нэг удаагийн тусламж, дэмжлэг	15,0	ОНТХ-өөр хэрэгжүүлэх чиг үүрэг биш
5	3.1.4 Төрийн байгууллагуудын “ЭЙБЛ” программ ашиглалтын зардал, аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимын тоног, төхөөрөмж	8,2	Удирдлагын зардал
6	3.1.7 Гадаад, дотоодын зочид төлөөлөгчдийг хүлээн авах, хүндэтгэл үзүүлэх зардал	45,0	Удирдлагын зардал
7	3.1.8. Гадаад арга хэмжээний зардал.	20,0	Удирдлагын зардал
8	3.1.9. Манлайбаатар Дамдинсүрэнгийн мэндэлсний 150 жилийн ой	15,0	Тооцоо судалгаагүй
9	3.1.14. Сумдын цагдаагийн албан хаагчдад шатахууны дэмжлэг	35,4	ОНТХ-өөр хэрэгжүүлэх чиг үүрэг биш
10	3.1.15. Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэх зардал	15,0	Хөтөлбөргүй /ГХУСЗ-аас санхүүжүүлэх/
11	3.1.18 Үндэсний аюулгүй байдлыг хангах болон терроризмтэй тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөлийн Дорнод аймгийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардал	15,0	ОНТХ-өөр хэрэгжүүлэх чиг үүрэг биш
12	3.1.21. Татвар төлөгчдийн өдрүүдийг зохион байгуулах/аймгийн төв, 13 сумдад/	10,0	ОНТХ-өөр хэрэгжүүлэх чиг үүрэг биш
13	3.1.22. Хууль зүйн үйлчилгээний төлбөр /ИТХ, ЗДТГ/	10,0	ОНТХ-өөр хэрэгжүүлэх чиг үүрэг биш
14	3.2.1. Ахмадын байгууллагын нэгжийн удирдлагыг урамшуулна. /14 сум, Хэрлэн сумын 11 баг	63,0	Урсгал зардал
15	3.2.6. Халуун усны газруудын үйл ажиллагаанд дэмжлэг /Хэрлэн сум/	8,3	урсгал зардал
16	3.2.3. Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөрийг хэрэгжүүлэх	7,5	хөтөлбөр батлагдаагүй
17	3.3.8. Англи хэлтэй Дорнодчууд хөтөлбөр	15,0	хөтөлбөр батлагдаагүй
18	3.3.11. Эмэгтэйчүүдийн хөгжил, оролцоо, манлайллыг хөгжүүлэх зорилгоор “Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр”-ийг боловсруулан хэрэгжүүлэх	7,5	хөтөлбөр батлагдаагүй
19	3.3.13. Уламжлалт боловсрол төсөл хэрэгжүүлэх зардал	7,5	хөтөлбөр батлагдаагүй
20	3.3.16. Аймгийн “Ахмадын ачлал” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	7,5	хөтөлбөр батлагдаагүй
21	3.4.1. Жилийн эцсийн мал тооллогын зардал	8,0	ОНТХ-өөр хэрэгжүүлэх чиг үүрэг биш

Дорнод аймгийн 2021 оны төсвийн төсөлд өгөх санал, дүгнэлт

22	3.4.5. Зөгийчдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт	4,0	үр ашиггүй
23	3.3.15. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгааллын хөтөлбөр”-ийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх	20,0	1 заалтыг 2 дахин оруулсан
24	3.1.5. Орон нутагт нэн дутагдалтай багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудын сургалтын төлбөрт дэмжлэг	20,0	төсвийн төслийн 3.1.5 дахь заалтад орсон, тооцоо судалгаагүй
25	3.5.3 Гамшгийн эрсдэлээс хамгаалах судалгаа хийх /бүх сумдад/	20,0	Тооцоо судалгаагүй
26	3.6.1 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих бүтээн байгуулалтын ажил /авто зам, инженерийн шугам сүлжээ, барилга, байгууламж/ барьж байгуулахад өмчлөл, эзэмшлийн газар нь давхацсан иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшил, өмчлөлийн газар чөлөөлөх, нөхөн олговор олгох ажлыг зохион байгуулах зардал	50,0	Тооцоо судалгаагүй
Нийт		560,4	

2. Төсвийн тооцоолол нь алдаатай, тооцоо судалгаа нь дутуу, хөтөлбөрийн үр дүнг сайжруулах зэрэг иж бүрэн байдлыг хангаагүй 312.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээний **үр дүнг сайжруулах** саналыг гаргаж байна. Үүнд:

Хүснэгт №5. “Үр дүнг сайжруулах төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүд-ХОБ төсөл, хөтөлбөр”


№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөвт өртөг /сая.төг/	Тайлбар
1	3.1.1. Баяр ёслолын үеэр олгох аймгийн нэрэмжит шагналын зардал	38,5	Төсвийн тооцоолол алдаатай
2	3.1.5. Орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр суралцаж буй оюутнуудад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх, "Нутгийн ирээдүй" төсөл хэрэгжүүлэх	160,0	Төсөл, тооцоо судалгаа дутуу
3	3.1.12.Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих үүрэг бүхий Иргэний зөвлөлийн үйл ажиллагааны зардал	10,0	Төсөл, тооцоо судалгаа дутуу
4	Цэргийн болон цэргийн өмнөх насны залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх ажлыг зохион байгуулах	15,0	Хүрэх үр дүнг бодитой болгох
5	3.1.23. Сайн санхүүч хөтөлбөр хэрэгжүүлэх	38,0	Хөтөлбөр ирүүлээгүй, хөтөлбөрт спортын биш эрдэм шинжилгээний үйл ажиллагаанууд оруулах
6	3.1.16. Батлан хамгаалах салбарын үйл ажиллагаанд зарцуулах зардал	51,0	Тооцоо судалгаа нь задаргаагүй бөөн дүнгээр төсөвлөгдсөн
Нийт		312,5	

4.3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН

Аймгийн ОНХС-гийн Төсвийн төсөлд санал, дүгнэлт өгөхдөө Төсвийн тухай хуулийн 58, 59, 60 дугаар зүйл, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан ОНХС-гийн үйл ажиллагааны журам, Сангийн сайдын 2012 оны 244 тушаалаар батлагдсан орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам, Сангийн яамны 2021 оны төсвийн төсөл боловсруулах удирдамжийг шалгуур болгон авч үзлээ.

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 8.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд хийсэн дүн шинжилгээ.

Дүрслэл № 2. “ОНХС-гийн төсөл, хөтөлбөрт хийсэн дүн шинжилгээ”



ОНХС-гийн төсвийн төсөлд хууль, журмын шаардлагад нийцэхгүй дараах асуудлууд байна.

1. ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2, Сангийн Сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан ОНХС-гийн үйл ажиллагааны журмын 4.1, 4.2 хэсэгт заасантай нийцээгүй 978.7 сая төгрөгийн 23 хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээг ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад оруулсан байна.

Хүснэгт №6.

“ОНХС-гаар хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй төсөл, арга хэмжээ”

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Мөнгөн дүн /мян.төг/
1	Орон нутгийн өмчийн орон сууцыг шинээр бий болгоход дэмжлэг /Гурванзагал сум/	100,000.0
2	Орон нутгийн өмчийн орон сууц барихад дэмжлэг үзүүлэх	80,000.0
3	БОЭТ-ийн цахилгаан шатны засвар	93,000.0
4	БОЭТ-ийн Амбулаторийн барилга, Сүрьеэгийн тасгийн засвар тохижилт	151,800.0
5	Хэрлэн сумын 2, 3-р багийн төв гудамжны хашаа, гэрэлтүүлэг, барилгын нүүрэн талын фасадын ажлыг эхлүүлэх	199,400.0
6	Хохирогчийг хамгаалах “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн хамгаалах, урьдчилан сэргийлэх, нийгмийн ажил үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх	15,000.0
7	“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр”, “Эрүүл эмэгтэй хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх	20,000.0
8	“Эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд арга хэмжээ” Эхчүүдээ хайрлая хөтөлбөрийн хүрээнд вакцинд хамруулах	15,000.0

Дорнод аймгийн 2021 оны төсвийн төсөлд өгөх санал, дүгнэлт

9	"Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх /2017-2026 он/	50,000.0
10	"Элэгний В вирусын халдваргүй нярай" төслийг үргэлжлүүлж, дархлал тогтцыг үнэлэх	15,000.0
11	Өсвөр үе залуучуудын эрүүл мэндийг дэмжих төсөл хэрэгжүүлэх /14-17 насны/	10,000.0
12	"Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээ" БЗДХ-аас урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах төсөл	70,000.0
13	"Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээ" Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах төсөл	10,000.0
14	"Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээ" Дархлаажуулалтын үйл ажиллагааг өргөжүүлэх, томуугийн вакцинд хамруулах	15,000.0
15	"Халдварт бус өвчнөөс сэргийлэх" төсөл хэрэгжүүлэх	24,000.0
16	"Хавдрын эсрэг хамтдаа" аян, арга хэмжээ зохион байгуулах	5,000.0
17	"Харшлаас сэргийлэх" арга хэмжээ зохион байгуулах	10,000.0
18	Оюутны эрүүл мэндийг дэмжих /Эрүүл оюутан төсөл/	20,000.0
19	Хөдөөгийн хүн амд төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчийн тусламж, үйлчилгээг хүргэх "Хөдөлгөөнт эмнэлэг" ажиллуулах	25,000.0
20	Орон нутгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнг өндөр хөгжилтэй улсад суралцахад дэмжлэг үзүүлэх	12,500.0
21	Хөдөө орон нутагт эмнэлгийн ажилтанг тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлэх урамшууллыг үе шаттай олгоно	15,000.0
22	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд аймаг, сумын төвийн алслагдсан зарим багуудад эмийн сан ажиллуулах	18,000.0
23	"Элэг бүтэн Монгол" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	5,000.0
	Дүн	978,700.0

2. ОНХС-гаас шинээр барилга байгууламж, өмч бий болгоход нийт 529.0 сая төгрөгийн 5 барилга байгууламж, өмчид Сангийн Сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.1.7 Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-гийн ажлын хэсэг нь тус сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санал болгож буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргах", гэж заасны дагуу дүгнэлт гаргаагүй байна. Энэ нь "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.3 "ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний санал нь энэ журмын 3 дугаар бүлэгт заасан нөхцөлийг хангаагүй, мөн 4.2-т заасныг хэрэгжүүлэхээр бол нэгдсэн жагсаалтаас хасах үндэслэл болно."

Хүснэгт №7. "Хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлт гаргаагүй төсөл арга хэмжээ"

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Мөнгөн дүн /мян.төг/
1	Багийн бага сургууль байгуулахад дэмжлэг	80,000.0
2	Хэрлэн сумын 2, 3-р багийн өрхийн эмнэлгийн салбар шинээр барих	200,000.0
3	Багш нарын сургалт, дадлагын төв байгуулах	50,000.0
4	Ахмадын настнуудын чөлөөт цагийн төвийн байр /Хэрлэн сум, 10-р баг/	89,000.0
5	Сурагчийн автобус /Хэрлэн, Баян-Уул сум/	110,000.0
	Дүн	529,000.0

3. Зураг төсөв, тооцоо судалгаагүй 206.1 сая төгрөгийн 6 хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ байна. Энэ нь Сангийн Сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.3 “ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, тенхик, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна. Энэ нь “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3 “ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний санал нь энэ журмын 3 дугаар бүлэгт заасан нөхцөлийг хангаагүй, мөн 4.2-т заасныг хэрэгжүүлэхээр бол нээгдсэн жагсаалтаас хасах үндэслэл болно.”

Хүснэгт №8.

“Зураг, төсөвгүй төсөл арга хэмжээ”

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Мөнгөн дүн /мян.төг/
1	Багийн бага сургууль байгуулахад дэмжлэг	80,000.0
2	Хэрлэн сум, 11-р баг, 406-р байрны боловсон ариун цэврийн байгууламж	30,134.6
3	Эко ариун цэврийн байгууламж /Баянтүмэн сум/	25,000.0
4	Музейн засвар /Гурванзагал сум/	20,000.0
5	Нийтийн орон сууцны барилгын засвар /Хэрлэн сум, 1 дүгээр баг, 12 айлын орон сууц/	40,000.0
6	Орон нутгийн өмчийг түр хадгалах, хамгаалахад зориулсан хашаа, байрны засвар	11,000.0
Дүн		206,134.6

4. Сангийн Сайдын 2012 оны 244 тушаалаар батлагдсан орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журамд заасны дагуу хөрөнгө оруулалт, хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг төсвийн төслийн хавсралт байдлаар боловсруулаагүй байна.

5. Үр ашиггүй, хэмнэлтгүй тэвчиж болох 898.4 сая төгрөгийн 10 төсөл арга хэмжээнд хөрөнгө төлөвлөсөн байна.

Хүснэгт №9

“Хэмнэлтгүй, үр ашиг тодорхойгүй, тэвчиж болох төсөл, арга хэмжээ”

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Мөнгөн дүн /мян.төг/
1	Орон нутгийн өмчийн орон сууцыг шинээр бий болгоход дэмжлэг /Гурванзагал сум/	100,000.0
2	Орон нутгийн өмчийн орон сууц барихад дэмжлэг үзүүлэх	80,000.0
3	Багш нарын сургалт, дадлагын төв байгуулах	50,000.0
4	Жишиг гэр хороолол төсөл эхлүүлэх	65,000.0
5	Ахмадын настуудын чөлөөт цагийн төвийн байр /Хэрлэн сум, 10-р баг/	89,000.0
6	Хэрлэн сумын 2, 3-р багийн төв гудамжны хашаа, гэрэлтүүлэг, барилгын нүүрэн талын фасадын ажлыг эхлүүлэх	199,400.0
7	Аймгийн төв цэнгэлдэх хүрээлэнгийн засвар, тохижилт /Хэрлэн сум/	85,000.0
8	Партизан Содномдаржаагийн хөшөөний засвар, тохижуулалт	20,000.0
9	Сурагчийн автобус /Хэрлэн, Баян-Уул сум/	110,000.0
10	Илч хорооллын хайрган хучилттай авто замын хатуу хучилттай авто зам болгон барих /660 м/	100,000.0
Дүн		898,400.0

6. Батлагдсан зураг, төсвөөс зөрүүтэй төлөвлөсөн, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх хугацааг бодитой тооцоогүй, төсвийн үр ашгийг сайжруулах шаардлагатай нийт 2573.0 сая төгрөгийн 22 төсөл арга хэмжээ байна.

Хүснэгт №10.

“Үр ашгийг сайжруулах төсөл, арга хэмжээ”

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Мөнгөн дүн /мян.төг/
1	Орон сууцны нийтийн эзэмшлийн шугамыг цэвэр усны төвлөрсөн шугаманд холбох /Хэрлэн сум, 8-р баг/	115,000.0
2	Багш нарын сургалт, дадлагын төв байгуулах	50,000.0
3	Жишиг гэр хороолол төсөл эхлүүлэх	65,000.0
4	Ахмадын настнуудын чөлөөт цагийн төвийн байр /Хэрлэн сум, 10-р баг/	89,000.0
5	Эрүүл мэнд, боловсрол, соёлын салбарын төсөвт байгууллагуудын цахилгаан, сантехникийн системийг засварлах шинэчлэх ажилд дэмжлэг	60,000.0
6	Нийтийн орон сууцны барилгын дээврийн засвар /Хэрлэн сум, Халхгол сум, Чулуунхороот сум/	450,000.0
7	Нийтийн орон сууцны барилгын дуулаалга гадна фасадыг шинэчлэх /Хэрлэн сум/	210,000.0
8	Нийтийн орон сууцны байрны зоорийн давхрын шугам сүлжээг засварлах /Хэрлэн сум, 9-р баг/	130,000.0
9	Аймгийн төв цэнгэлдэх хүрээлэнгийн засвар, тохижилт /Хэрлэн сум/	85,000.0
10	Хүүхдийн тоглоомын болон чийрэгжүүлэлтийн талбай нэмж байгуулах /аймгийн төвд болон сумдад/	220,000.0
11	Хэрлэн голын эргийг талхагдлаас хамгаалах зорилгоор авто машины зогсоол, явган хүний зам барих /Хэрлэн сум/	120,000.0
12	Хатуу хучилттай зам, зогсоол барих /Хэрлэн сум, 4-р баг, Гандангийн гудамж/	144,000.0
13	Илч хорооллын хайрган хучилттай авто замын хатуу хучилттай авто зам болгон барих /660 м/	100,000.0
14	Урд болон хойд төв авто зам дагуу гэрлийн шон, замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулах	25,000.0
15	Төв замын гэрэлтүүлгийн шинэчлэлт	30,000.0
16	Орон сууцны хорооллын гадна гэрэлтүүлэг, камержуулалт бүхий авто машины зогсоол байгуулах /Хэрлэн сум/	90,000.0
17	Гэр хорооллын гудамж талбайд гэрэлтүүлэг /Хэрлэн сум/	120,000.0
18	Гэр хорооллын цахилгаан хангамжийг сайжруулах /Хэрлэн сум 1, 10, 11-р баг/	100,000.0
19	Буйр нуурын эрэг дагуу ЦДАШ, дэд станц шинээр барих	120,000.0
20	“Шинэ усан сан-7” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	120,000.0
21	Ундны усны цэвэр усны гүний худаг шинээр гаргах /Матад сум, Хангай хороолол/	50,000.0
22	Дорнод аймагт 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын барилга, байгууламж, их засварын ажлын зураг төслийн зардал	80,000.0
	Дүн	2,573,000.0

САНАЛ:

1. Хууль, журамд нийцээгүй нийт 1553.8 сая төгрөгийн 32 төсөл арга хэмжээг хасах санал оруулж байна.

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Мөнгөн дүн
1	Орон нутгийн өмчийн орон сууцыг шинээр бий болгоход дэмжлэг /Гурванзагал сум/	100000
2	Орон нутгийн өмчийн орон сууц барихад дэмжлэг үзүүлэх	80000
3	БОЭТ-ийн цахилгаан шатны засвар	93000
4	БОЭТ-ийн Амбулаторийн барилга, Сүрьеэгийн тасгийн засвар тохижилт	151800
5	Хэрлэн сумын 2, 3-р багийн төв гудамжны хашаа, гэрэлтүүлэг, барилгын нүүрэн талын фасадын ажлыг эхлүүлэх	199400
6	Хохирогчийг хамгаалах “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн хамгаалах, урьдчилан сэргийлэх, нийгмийн ажил үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх	15000
7	“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр”, “Эрүүл эмэгтэй хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх	20000
8	“Эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд арга хэмжээ” Эхчүүдээ хайрлая хөтөлбөрийн хүрээнд вакцинд хамруулах	15000
9	“Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх /2017-2026 он/	50000
10	“Элэгний В вирусын халдваргүй нярай” төслийг үргэлжлүүлж, дархлал тогтцыг үнэлэх	15000
11	Өсвөр үе залуучуудын эрүүл мэндийг дэмжих төсөл хэрэгжүүлэх /14-17 насны/	10000
12	“Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээ” БЗДХ-аас урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах төсөл	70000
13	“Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээ” Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах төсөл	10000
14	“Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээ” Дархлаажуулалтын үйл ажиллагааг өргөжүүлэх, томуугийн вакцинд хамруулах	15000
15	“Халдварт бус өвчнөөс сэргийлэх” төсөл хэрэгжүүлэх	24000
16	“Хавдрын эсрэг хамтдаа” аян, арга хэмжээ зохион байгуулах	5000
17	“Харшлаас сэргийлэх “арга хэмжээ зохион байгуулах	10000
18	Оюутны эрүүл мэндийг дэмжих /Эрүүл оюутан төсөл/	20000
19	Хөдөөгийн хүн амд төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчийн тусламж, үйлчилгээг хүргэх “Хөдөлгөөнт эмнэлэг” ажиллуулах	25000
20	Орон нутгийн эмч, эмнэлгийн мэргэжилтийг өндөр хөгжилтэй улсад суралцахад дэмжлэг үзүүлэх	12500
21	Хөдөө орон нутагт эмнэлгийн ажилтныг тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлэх урамшууллыг үе шаттай олгоно	15000
22	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд аймаг, сумын төвийн алслагдсан зарим багуудад эмийн сан ажиллуулах	18000
23	“Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	5000
24	Хэрлэн сумын 2, 3-р багийн өрхийн эмнэлгийн салбар шинээр барих	200000
25	Багш нарын сургалт, дадлагын төв байгуулах	50000
26	Ахмадын настнуудын чөлөөт цагийн төвийн байр /Хэрлэн сум, 10-р баг/	89000
27	Сурагчийн автобус /Хэрлэн, Баян-Уул сум/	110000
28	Хэрлэн сум, 11-р баг, 406-р байрны боловсон ариун цэврийн байгууламж	30134.6
29	Эко ариун цэврийн байгууламж /Баянтүмэн сум/	25000
30	Музейн засвар /Гурванзагал сум/	20000
31	Нийтийн орон сууцны барилгын засвар /Хэрлэн сум, 1 дүгээр баг, 12 айлын орон сууц/	40000
32	Орон нутгийн өмчийг түр хадгалах, хамгаалахад зориулсан хашаа, байрны засвар	11000
	Дүн	1,553,834.6

2. Төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх нийт 2653.4 сая төгрөгийн 22 төсөл арга хэмжээний саналыг оруулж байна.

Хүснэгт №12

“Төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх”

/мян.төг/

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Мөнгөн дүн
1	Хэрлэн сумын 2, 3-р багийн төв гудамжны хашаа, гэрэлтүүлэг, барилгын нүүрэн талын фасадын ажлыг эхлүүлэх	199400
2	Партизан Содномдаржаагийн хөшөөний засвар, тохижуулалт	20000
3	Орон сууцны нийтийн эзэмшлийн шугамыг цэвэр усны төвлөрсөн шугамд холбох /Хэрлэн сум, 8-р баг/	115000
4	Жишиг гэр хороолол төсөл эхлүүлэх	65000
5	Эрүүл мэнд, боловсрол, соёлын салбарын төсөвт байгууллагуудын цахилгаан, сантехникийн системийг засварлах шинэчлэх ажилд дэмжлэг	60000
6	Нийтийн орон сууцны барилгын дээврийн засвар /Хэрлэн сум, Халхгол сум, Чулуунхороот сум/	450000
7	Нийтийн орон сууцны барилгын дуулаалга гадна фасадыг шинэчлэх /Хэрлэн сум/	210000
8	Нийтийн орон сууцны байрны зоорийн давхрын шугам сүлжээг засварлах /Хэрлэн сум, 9-р баг/	130000
9	Аймгийн төв цэнгэлдэх хүрээлэнгийн засвар, тохижилт /Хэрлэн сум/	85000
10	Хүүхдийн тоглоомын болон чийрэгжүүлэлтийн талбай нэмж байгуулах /аймгийн төвд болон сумдад/	220000
11	Хэрлэн голын эргийг талхагдлаас хамгаалах зорилгоор авто машины зогсоол, явган хүний зам барих /Хэрлэн сум/	120000
12	Хатуу хучилттай зам, зогсоол барих /Хэрлэн сум, 4-р баг, Гандангийн гудамж/	144000
13	Илч хорооллын хайрган хучилттай авто замын хатуу хучилттай авто зам болгон барих /660 м/	100000
14	Урд болон хойд төв авто зам дагуу гэрлийн шон, замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулах	25000
15	Төв замын гэрэлтүүлгийн шинэчлэлт	30000
16	Орон сууцны хорооллын гадна гэрэлтүүлэг, камержуулалт бүхий авто машины зогсоол байгуулах /Хэрлэн сум/	90000
17	Гэр хорооллын гудамж талбайд гэрэлтүүлэг /Хэрлэн сум/	120000
18	Гэр хорооллын цахилгаан хангамжийг сайжруулах /Хэрлэн сум 1, 10, 11-р баг/	100000
19	Буйр нуурын эрэг дагуу ЦДАШ, дэд станц шинээр барих	120000
20	“Шинэ усан сан-7” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	120000
21	Ундны усны цэвэр усны гүний худаг шинээр гаргах /Матад сум, Хангай хороолол/	50000
22	Дорнод аймагт 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын барилга, байгууламж, их засварын ажлын зураг төслийн зардал	80000
	Дүн	2,653,400.0

БҮЛЭГ 5. САНГИЙН ЗАРДЛУУД

5.1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ ЗАРДАЛ

Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал:

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын орлогыг бүрдүүлэхдээ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу энэ

Дорнод аймгийн 2021 оны төсвийн төсөлд өгөх санал, дүгнэлт

хуулийн 13.2¹-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно:

Хүснэгт №13. “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн хувь, хэмжээ”

Байгалийн баялгийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төрөл	Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хувь, хэмжээний доод хязгаар /нийт орлогын дүнгээс хувиар/
1. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого	15 хувь
2. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	50 хувь
3. Газрын нөөцийн төлбөрийн орлого	15 хувь
4. Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	85 хувь
5. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	35 хувь

Орон нутгийн татварт 2021 онд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр СЯ-наас хянасан төсвөөр 3,940.0 сая төгрөг байхаар төлөвлөснийг аймгийн төсөвт хэвээр төлөвлөсөн байна.

Хүснэгт №14.

“Орлого” /сая.төгрөг/

№	ТАТВАРЫН АНГИЛАЛ	СЯ-НААС ХЯНАСАН	АЙМАГ	НИЙТ	ЗӨРҮҮ
1	Байгалийн ургамал	0	0	0	0
2	Ус рашаан	3900,0	3900,0	3900,0	0
3	Ан амьтан	0	0	0	0
4	Ойн нөөц	40,0	40,0	40,0	0
	Нийт	3940,0	3940,0	3940,0	0

Хүснэгт №15.

“Зарлага” /сая.төгрөг/

№	ТАТВАРЫН АНГИЛАЛ	СЯ-НААС ХЯНАСАН	ХУУЛИАР ЗАРЦУУЛАХ		ТӨСВИЙН ТӨСӨЛД	ЗӨРҮҮ	ХУВЬ
			ХУВЬ	ХЭМЖЭЭ			
1	Байгалийн ургамал	0	15	0	0	0	0
2	Ус рашаан	3900,0	35	1365,0	228,0	-1137,0	-83,2
3	Ан амьтан	0	50	0	30,0	30,0	-
4	Ойн нөөц	40,0	85	34,0	246,7	212,7	625,5
5	Байгаль орчны цэвэрлэгээ, нөлөөллийн ажил	0	0	0	214,4	214,4	-
6	Шилжих хөрөнгө	0	0	0	316,4	316,4	-
	Нийт	3940,0		1369,0	1035,5	-363,5	

Орлого: Ус, рашаан, ойн нөөцөөс орж ирэх төлбөрийг СЯ-наас 3,940.0 сая төгрөг байхаар төлөвлөснийг аймгийн төсөвт энэ дүнгээр төлөвлөсөн байна. Цар тахлын үед хил, гааль ажиллахгүй байгаатай холбогдуулан бусад татвараас /байгалийн ургамал, ан амьтан/ орлого орж ирэхгүй байхаар төлөвлөсөн байна.

¹ 13.2.Төлбөрийн орлогын хэсгийг дор дурдсан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос бүрдүүлнэ:
 13.2.1. байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого; 13.2.2. ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого; 13.2.3. ойн нөөц ашигласны төлбөрийн орлого;
 13.2.4. ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого; 13.2.5.газрын нөөцийн төлбөрийн орлого.

Зарлага: Хуулиар зарцуулах хувь хэмжээг 1369.0 сая төгрөг байхаар заасан ч 1,035.5 сая төгрөг буюу 363.5 сая төгрөгөөр дутуу зарцуулахаар төлөвлөсөн байна. Мөн ус, рашаанаас орж ирсэн төлбөрийг 1,137.0 сая төгрөгөөр дутуу буюу хуульд заасан хэмжээнээс 83.2 хувиар дутуу зарцуулахаар төлөвлөсөн байна.

Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоол “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 1.2-т “*Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг тухайн ашигласан нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах, хяналт тавих арга хэмжээнд зарцуулна.*” гэж заасан байна. Гэтэл 807.5 сая төгрөгийг ан амьтан, ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, байгаль орчны цэвэрлэгээ, нөлөөллийн ажил, өмнөх оноос шилжиж ирсэн төсөл, арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөж, СЯ-наас хянаж батлаагүй байхад илүү зарцуулахаар төлөвлөсөн байна.


ДҮГНЭЛТ:

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг 2021 онд нийт 1,035.5 сая төгрөг байхаар төлөвлөж, 316.4 сая төгрөгийг өмнөх оны 8 төсөл, арга хэмжээнд зарцуулахаар шилжүүлж, шинээр хэрэгжүүлэх 34 төсөл арга хэмжээнд 719.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Үүнээс 560.1 сая төгрөгийн 22 төсөл, арга хэмжээний холбогдох зураг төсөв, ажлын даалгавар, төлөвлөгөөг төсөл байдлаар ирүүлсэн боловч иж бүрэн байх шаардлагыг хангасан 220.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ, хангаагүй 390.1 сая төгрөгийн 19 төсөл, арга хэмжээ байна.

Дүрслэл№ 3

“Төсөл арга хэмжээний төлөвлөлт, БХНСЗ”



Ажлын төсөв, тооцоолол, даалгавар, удирдамж, төлөвлөгөө нь хийгдээгүй 109.0 сая төгрөгийн 12 төсөл, арга хэмжээ байна. /Төсөв, тооцоо, ажлын даалгавар, удирдамж, төлөвлөгөө нь хийгдээгүй ажлуудад 2.1.2, 2.1.6, 2.1.8, 2.2.2, 2.2.4, 2.2.12, 2.4.1, 2.4.6-2.4.10 дахь төсөл, арга хэмжээнүүд хамаарна./

СЯ-наас аймгийн БОАЖГ-т 2020 онд 1.4 тэрбум төгрөгийн байгаль орчин нөхөн сэргээх зардлыг хянаж хуваарилж, ИТХ-ын тогтоолоор баталсан байхад аймгийн Засаг дарга уг төсвийг өрийн захиран зарцуулах төсвийн багцад авч шууд захиран зарцуулж ажилласан байна. Өмнөх оны төсвийн төсөлд энэ талаар санал өгсөн боловч хэрэгжүүлээгүй, ирэх 2021 оны төсвийн төсөлд СЯ-наас хянасан төсвийн хуваарь, аймгийн ИТХ-ын тогтоолыг мөрдөж ажиллах нь зүйтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;”, МӨН СЯ-наас хянаж баталсан төсвийг тус тус зөрчиж, ТШЗ-ийн үүргийг ТЭЗ хэрэгжүүлсэн байна.

САНАЛ:

1. СЯ-наас хянасан төсвийн багцад байгаль орчныг нөхөн сэргээх төсөл, арга хэмжээний төсвийг БОАЖГ-т баталсан. Иймд захиран зарцуулах эрхийг хэрэгжүүлэх үүрэг бүхий ТШЗ-д хуваарилж, батлах.
2. Ажлын төсөв, тооцоо, ажлын даалгавар, удирдамж, төлөвлөгөө нь хийгдээгүй 109.0 сая төгрөгийн өртөгтэй 12 төсөл, арга хэмжээг **хасах саналыг** гаргаж байна. Үүнд:

Хүснэгт №16. “Ажлын төсөв, тооцоо, ажлын даалгавар, удирдамж, төлөвлөгөө нь хийгдээгүй төсөл, арга хэмжээнүүд”

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөвт өртөг /сая.төг/
1	2.1.2. Гол, нуур, рашаан, булаг, усны эх болон газрын доорх усны ордуудын гадаад тэжээгдлийн мужийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах	10,0
2	2.1.6. Сумын төвүүдийн ус хангамжийн эх үүсвэрүүдийн чанарын судалгааг хийх	10,0
3	2.1.8. Ус ашиглагч болон бохирдуулагч аж ахуйн нэгжүүдийн усны хэрэглээ, ашиглалтад хяналт хийж тоолууржуулах ажил	3,0
4	2.2.2. Хилийн зурвасын дагуу түймрээс хамгаалах шороон зурвасыг сэргээх зардал	30,0
5	2.2.4. Уул уурхайн нөлөөгөөр эвдрэлд орсон газрын судалгаа, ажлын зургийн хамт	10,0
6	2.2.12. Аймгийн хэмжээнд уул уурхайн аж ахуйн нэгжийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, газрын хэвлийн нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, ажлын үр дүнд мониторинг хийнэ.	5,0
7	2.4.1. Нэг голын хүүхдүүд төслийн хүрээнд бүх сумдын сурагчдын дунд түүх, дүрслэх урлаг, хүрээлэн буй орчин, байгалийн ухааны хичээлүүдээр олимпиад, уралдаан зохион байгуулах.	25,0
8	2.4.6. Сумдын Засаг даргын тамгын газар, ИТХ, Байгаль орчны тасаг, экологийн цагдаагийн албан хаагчдад байгаль орчны багц хуулийн сургалт зохион байгуулж гарын авлагаар хангах	3,0
9	2.4.7. Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагчдыг давтан сургах, үе шаттайгаар сургалтад хамруулах.	3,0
10	2.4.8. Байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчлийг бууруулах зорилгоор нэгдсэн хяналт шалгалтыг хууль хяналтын байгууллагуудтай хамтран зохион байгуулах.	3,0
11	2.4.9. Covid 19 цар тахлын улмаас үүссэн нөхцөл байдалтай холбогдуулж 90 цагийн теле хичээлийг хөл хорионы үед орон нутгийн телевиз, сошиал медиа ашиглан ЕБС-ын сурагчдад хүргэх.	2,0
12	2.4.10. Нийтийн эзэмшлийн гудамж, талбай, ногоон бүсэд хөдөлгөөнт эргүүл явуулна.	5,0
Нийт		109,0

3. Ажлын төсөв, төлөвлөгөө, даалгавар, техникийн тодорхойлолтыг батлуулаагүй, төсвийн тооцооллын задаргаа нь бүрэн хийгдээгүй зэрэг иж бүрэн байдлыг хангаагүй 390.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 төсөл, арга хэмжээний **үр дүнг сайжруулах** саналыг гаргаж байна. Үүнд:

Хүснэгт №17. “Ажлын төсөв, төлөвлөгөө, даалгавар, техникийн тодорхойлолтыг батлуулаагүй, төсвийн тооцооллын задаргаа нь бүрэн хийгдээгүй төсөл, арга хэмжээнүүд”

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөвт өртөг /сая.төг/	Тайлбар
---	-------------------------	------------------------	---------

Дорнод аймгийн 2021 оны төсвийн төсөлд өгөх санал, дүгнэлт

1	2.1.4. Рашаан, булаг, шандын эхийг хашиж хамгаалах зардал	46,0	Төсвийн тооцоолол дутуу, ажлын даалгаврыг батлуулаагүй
2	2.1.5. Усны тоо бүртгэлийг аймгийн хэмжээнд зохион байгуулах зардал	9,0	Төсвийн тооцооллыг батлуулаагүй
3	2.1.7. Буйр нуурын эрэг орчмын цөлжилт, элсний нүүдлээс хамгаалах менежмент төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар хийлгэх.	10,0	Ажлын даалгаврыг батлуулаагүй
4	2.2.1. Цөлжилтөөс сэргийлэх зорилгоор бэлчээр, хадлангийн талбайн нөөцийг тодорхойлох	20,0	Төсвийн тооцоолол дутуу, үйл ажиллагааны зардлын задаргаа байхгүй.
5	2.2.5. Түймэрт шатсан, хөнөөлт шавжид нэрвэгдсэн, мод бэлтгэсэн 50 га талбайд ойжуулалт хийнэ.	34,7	Төсвийн тооцоолол байхгүй, ажлын даалгаврыг батлуулаагүй.
6	2.2.6. Бүх нийтээр мод тарих аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажил	5,0	Ажлын даалгавар байхгүй, төсвийн тооцооллыг холбогдох албан тушаалтнаар хянуулаагүй.
7	2.2.7. “Ногоон паспорт-Ногоон төгөл”-3.5 га цэцэрлэгийн өргөтгөл, тохижилт, арчилгаа, хамгаалалтыг сайжруулна.	6,0	Ажлын даалгавар байхгүй, төсвийн тооцооллыг холбогдох албан тушаалтнаар хянуулаагүй.
8	2.2.8. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах зардал	30,0	Төсвийн тооцооллыг холбогдох албан тушаалтнаар хянуулаагүй. Төсвийн задаргаа байхгүй.
9	2.2.9. Чойбалсан хотын ногоон байгууламжийн хортон шавьж, өвчний судалгаа, тэмцэх ажил	20,0	Ажлын даалгаврыг батлуулаагүй, төсвийн тооцоолол хийгдээгүй.
10	2.2.10. Ойн нөхөрлөлүүдийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, дэмжлэг үзүүлэх	2,0	Төсвийн тооцооллыг холбогдох албан тушаалтнаар хянуулаагүй.
11	2.2.11. Сум дундын ойн анги, мод үржүүлгийн газрыг хашаажуулах	23,0	Ажлын төсвийн дүн 0,6 мянган төгрөгөөр хэтэрсэн дүнтэй, ажлын даалгаврыг батлуулаагүй.
12	2.2.13. Чойбалсан хот орчмын эвдэрсэн газруудад нөхөн сэргээлт хийх.	36,0	Ажлын даалгаврыг батлуулаагүй, ажлын төсөв, тооцоог хийгээгүй.
13	2.2.14. Сум дундын ойн ангийн барилгын засвар, тохижилт /Баян-Уул сум/	15,0	Ажлын төсвийн дүн 0,4 мянган төгрөгөөр хэтэрсэн дүнтэй.
14	2.3.1. Байгалийн нөөц газар болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгуудыг хамгаалах менежментийг сайжруулах	25,0	Ажлын даалгаврыг батлуулаагүй, төсвийн тооцоолол хийгдээгүй.
15	2.3.2. Байгалийн хүчин зүйлийн улмаас идэш тэжээл ховордсон зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авна.	5,0	Ажлын төлөвлөгөөг аймгийн ЗД-аар батлуулаагүй, төсвийн тооцоолол хийгдээгүй.
16	2.4.3. Агаарын бохирдол, хөрсний эвдрэлээс хамгаалах зорилгоор усан сангуудын хашаанд зүлэг, мод тарих	20,0	Ажлын даалгаврыг аймгийн ЗД-аар батлуулаагүй, төсвийн тооцоолол хийгдээгүй.
17	2.4.4. “Иргэдийн экологийн боловсрол, хүмүүжил, нөлөөллийн ажлыг зохион байгуулах, хогийг эх үүсвэрт нь ангилан ялгах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	25,0	Ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг батлуулаагүй, төсвийн тооцоолол хийгдээгүй.
18	2.4.5. Байгаль хамгаалагчдыг хувцас, техник хэрэгслээр хангах.	15,0	Ажлын даалгаврыг батлуулаагүй, техникийн тодорхойлолт хийгдээгүй.
19	2.4.11. Чойбалсан хотын одоогийн хогийн төв цэгийн 10 га газарт техникийн нөхөн сэргээлт хийнэ.	43,4	Ажлын даалгаврыг батлуулаагүй, ажлын төсөв хийгдээгүй.
Нийт		390,1	

2. Дорнод аймгийн Байгаль хамгаалалтын захиргааны зардал:

ДҮГНЭЛТ: Шинээр байгуулагдаж байгаа Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгуудын хамгаалалтын захиргааны зардалд СЯ-наас 121.7 сая төгрөгийг хянаж, аймгийн төсөвт энэ дүнгээр төлөвлөсөн байна.

Үүнээс үйл ажиллагааны зардалд 92.6 сая төгрөг, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, хур хог хаягдал зайлуулах зардалд 29.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна. Нөхөн сэргээх, хур хогийг зайлуулах зардлыг хэрхэн үр дүнтэй зарцуулах талаар урьдчилсан тооцоо, судалгаа, төлөвлөгөө хийгдээгүй байна.

САНАЛ: Нөхөн сэргээх, хур хогийг зайлуулах зардлыг хэрхэн үр дүнтэй зарцуулах талаар төсвийн задаргаа, төлөвлөгөө байхгүй учраас **хасах саналыг** гаргаж байна.

5.2. АВТО ЗАМЫН САН

Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоол “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ын 3.3-т заасны дагуу “Гэнэтийн хүчин зүйл буюу байгалийн гамшигт үзэгдэл, осол болсны улмаас авто зам, замын байгууламжид эвдрэл, гэмтэл үүссэний улмаас авто замын хөдөлгөөн хэвийн үргэлжлэх боломжгүй болсон тохиолдолд сэргээн засварлахад шаардагдах зардлыг авто замын сангийн тухайн жилийн төсвөөс тэргүүн ээлжинд санхүүжүүлнэ.” гэж заасан байна.

ДҮГНЭЛТ:

Авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний жагсаалтын 2.7 дахь 45.0 сая төгрөгийн өртөгтэй “Чойбалсан хот доторх авто замын ус зайлуулах системийг шинэчлэх” арга хэмжээний зураг, төсөв нь томсгосон байдлаар хийгдсэн боловч 19-р байрны ус зайлуулах системийг шинэчлэх ажлын төсөв хийгдээгүй, 2.8 дахь 5.0 сая төгрөгийн өртөгтэй “Гүүрүүдэд автомат хаалт” арга хэмжээний төсвийн тооцооллыг хийгээгүй байна.

Мөн хийгдсэн төсөв нь батлагдах төсвөөс зөрүүтэй дараах арга хэмжээнүүд байна.

- “Асфальт бетон авто замын засвар арчлалт /Уулзваруудыг нөхөж засварлах, хагарсан заадсыг хар лаваар бэхлэх”, санхүүжих дүн 78.5 сая төгрөг, ажлын төсөв 80.0 сая төгрөг.

- “Орон нутгийн чанартай хатуу хучилттай авто зам арчлалт, засвар”, санхүүжих дүн 25,0 сая төгрөг, ажлын төсөв 25.8 сая төгрөг.

- “Сайжруулсан болон шороон замын засвар арчлалт”, санхүүжих дүн 74.5 сая төгрөг, ажлын төсөв 7.8 сая төгрөг.

Ажлын төсвүүд нь санхүүжих дүнгээс 0.8-5.3 сая төгрөгөөр илүү байгааг сайжруулах шаардлагатай байна.

САНАЛ:

Зураг, төсөв, зардлын тооцоолол, үнийн судалгаа хийгдээгүй дээрх 2.7-2.8 дахь 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээнүүдийн зураг төсөв, төсвийн тооцооллыг сайжруулах шаардлагатай байна.

5.3. ХАЛАМЖИЙН САН

Халамжийн сангийн төсөв 2018 оноос улсын төсөвт шилжихдээ орон нутгийн шинж чанартай гэж үзэж Нийгмийн халамжийн тухай хуулийн 7.1 дэх “Халамжийн сангийн орлого дараах эх үүсвэрээс бүрдэнэ” гэсний 7.1.1-д “улс, орон нутгийн төсвөөс олгох хөрөнгө;”

заалтын хүрээнд онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг орон нутгийн төсвөөс санхүүждэг хэвээр үлдээсэн байна.

Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5²-д дурдагдсан иргэнд олгодог байна. Энэхүү тэтгэмжийг 2019 онд 91.2 сая төгрөг батлагдаж 76 иргэнд зарцуулж 92.8 мянган төгрөгийн чөлөөт үлдэгдэлд санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоож төсөвт төвлөрүүлсэн байна.

2020 онд 147.8 сая төгрөг батлагдаж 10 сарын байдлаар 86.4 сая төгрөгийг 72 иргэнд зарцуулж, хүлээгдэж буй гүйцэтгэлээрээ 98,4 сая төгрөг байна. 2020 он 11 сарын байдлаар нийт батлагдсан санхүүжилтийн 58.5 хувь буюу 86.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

ДҮГНЭЛТ: Онцгой тохиолдол болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид батлагдсан төсвөөс 61.4 сая төгрөгийг зарцуулаагүй байна. Урьдчилсан байдлаар 11, 12 дугаар сарын гүйцэтгэлийг өмнөх саруудын хамгийн өндөр зарцуулалттай сараар тооцон үзэхэд 12.0 сая төгрөгийг 2 дугаар сард зарцуулж байсан байна. Иймд бодит гүйцэтгэлийг 110.4 сая төгрөг гэж үзвэл 37.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

САНАЛ: Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдэл төвлөрүүлэх дансанд 37.4 сая төгрөгийг төвлөрүүлэх.

ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ:

1. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1-д аймгийн Засаг даргын бүрэн эрхэд 29.1.1. дэх а/ "... төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн Хуралд оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах" гэж заасан ч нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг аймгийн ИТХ-д танилцуулж байх
2. Төсвийн суурь зарлагыг Сангийн яамны баталсан хязгаараас нэмэгдүүлэн төлөвлөхгүй байх
3. МУЗЗНДНТХ-ийн 30.1.2 дахь заалтыг мөрдөн аймгийн Засаг дарга 1 орлогчтой ажиллах.
4. Аймгийн ОНХС, хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө төсвийн удирдлагын үндсэн зарчмыг баримталж, нотлох баримтад суурилан, орон нутгийн бодлогод тусгагдсан, нийгмийн нэн тэргүүний ач холбогдлоор нь эрэмбэлсэн, тооцоо судалгаанд үндэслэгдсэн, хуульд нийцсэн төсөл, арга хэмжээг төлөвлөж байх.

²ОНЦГОЙ ТОХИОЛДОЛ

13.5.1.гэнэтийн аюул, осол, урьдчилан төсөөлөх боломжгүй бусад шалтгаанаар гэр оронгүй, гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон болон амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрх;

13.5.2.18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн;

13.5.3.хорих ангиас суллагдсан өөрийн гэсэн гэр оронгүй, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн;

[/Энэ заалтыг 2015 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

13.5.4.нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай, дөрөв ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон эцэг, эх;

5. Орон нутгийн төсвийн хөрөнгийг тухайн шатны төсөвт хамаарахгүй арга хэмжээнд зарцуулахгүй байх.
6. Хөрөнгө оруулалтын бус хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжүүлэх байгууллагыг тодорхой тусгуулан батлуулах.
7. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг төлөвлөхдөө ажлын төсөв, төлөвлөгөө, даалгавар, техникийн тодорхойлолтыг батлуулж байх.
8. СЯ-наас хянасан төсвийн багцад байгаль орчныг нөхөн сэргээх төсөл, арга хэмжээний төсвийг БОАЖГ-т баталсан. Иймд захиран зарцуулах эрхийг хэрэгжүүлэх үүрэг бүхий ТШЗ-д хуваарилж, батлах.
9. Төсвийн тухай хуулийн 8.5.1 дэх цаглабарыг хэрэгжүүлэх.
10. Төсвийн төслийг хууль, журамд заасны дагуу тооцоо, судалгаа, нотлох баримтад үндэслэн бодитой төлөвлөж байх.

ДҮГНЭЛТ

Иймд орлого, зардлыг бодитой төлөвлөж, дээр дурдсан алдаа, зөрчлийг арилган, төсвийн төлөвлөлтийн үр ашгийг сайжруулах шаардлагатай байна.

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газраас аймгийн 2021 оны төсвийн төсөлд төсвийн үр ашгийг сайжруулах 7.5 тэрбум төгрөг, төсвийн орлогыг нэмэгдүүлэх 37.4 сая төгрөг, төсвийн зарлагыг бууруулах 2.7 тэрбум төгрөгийн санал, дүгнэлтийг хүргүүлж байна.

2021 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ

1. Төсвийн орлогыг нэмэгдүүлэх- 37.4 сая төгрөг
2. Төсвийн зарлагыг бууруулах- 2,658.2 сая төгрөгийн 77 төсөл, арга хэмжээ

Үүнд:

- Төсвийн зарлагын төлөвлөлт- 19.9 сая төгрөг
 - ОНТХО- 389.0 сая төгрөг
 - ХОБ- 560.4 сая төгрөг
 - ОНХС- 1,553.8 сая төгрөг
 - БОХНСЗ- 135.1
3. Төсвийн үр ашгийг дээшлүүлэх-7,530.4 сая төгрөгийн 54 төсөл, арга хэмжээ
 - Төсвийн орлогын үр ашгийг нэмэгдүүлэх- 2,038.0 сая төгрөг
 - Төсвийн зарлагын үр ашгийг сайжруулах- 1,996.9 сая төгрөг
 - ОНТХО- 124.4 сая төгрөг
 - ХОБ- 312.5 сая төгрөг
 - ОНХС- 2,653.4 сая төгрөг
 - БОХНСЗ - 390.1
 - АЗС- 50.0

АЙМГИЙН ИТХ-ЫН ХАРИУ

Аймгийн 2021 оны төсвийн төсөлд Төрийн аудитын газраас өгсөн санал дүгнэлтийн дагуу орлого нэмэгдүүлэх 157.1 сая төгрөг, зардал бууруулах 1,629.7 сая төгрөг, төсвийн үр ашгийг сайжруулах 2.5 тэрбум төгрөгийн дараах өөрчлөлтүүдийг орууллаа. Үүнд.

1. Төсвийн орлогыг 37.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналын дагуу Халамжийн сангийн 2020 оны үлдэгдлээс 37.4 сая төгрөгийг 2021 оны төсөвт татан төвлөрүүлэхээр тусгалаа.
2. Төсвийн зардлыг бууруулах 2,658.2 сая төгрөгийн саналын дагуу
 - Орон нутгийн төсвийн урсгал зарлагыг бууруулах 19.9 сая төгрөгийг аймгийн Засаг даргын тамгын газрын зардлаас хаслаа.
 - Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг бууруулах 389.0 сая төгрөгийн саналаас “Зүүн бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын гаражийн өргөтгөл”-ийн 100.0 сая төгрөг, “Манлайбаатар Дамдинсүрэнгийн онголсон газрын баганыг сэргээн засварлах” 15.0 сая төгрөг, “Стандарт хэмжил зүйн хэлтсийн албан хэрэгцээнд тоног төхөөрөмж худалдан авах” 12.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээнүүдийг хасаж, 262.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг аймгийн эдийн засаг, нийгмийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусган хуулийн шаардлагад нийцүүлээ.
 - Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын бус хөтөлбөр арга хэмжээний зардлыг бууруулах 560.4 сая төгрөгийн саналаас батлагдсан хөтөлбөргүй гэж үзэн хасах санал ирүүлсэн нийт 164.0 сая төгрөгийн 6 хөтөлбөр нь

1. “Төрийн албан хаагчийн сургалт, хөгжил хөтөлбөр” 2017 оны 01 дүгээр тогтоол

2. “Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр” 2019 оны 78 дугаар тогтоол

3. “Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөр”

4. “Англи хэлтэй Дорнодчууд хөтөлбөр”

5. “Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр”

6. “Ахмадын ачлал хөтөлбөр”

аймгийн ИТХ-ын тогтоолуудаар батлагдсан, мал тооллогын 8.0 сая төгрөгийн 1 арга хэмжээний санхүүжилтийг Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолоор аймгийн Засаг даргад хариуцуулсан байгаа тул тус тус хэвээр үлдээж, 15.0 сая төгрөгийн “Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр” хэрэгжүүлэх зардлыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд, 20.0 сая төгрөгийн “Гамшгийн эрсдэлээс хамгаалах судалгаа хийх” зардлыг орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх ажилд шилжүүлэн хуулийн шаардлагад нийцүүлж, 353.4 сая төгрөгийн 17 төсөл, арга хэмжээг

1. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагаа,

2. Зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх нэг удаагийн тусламж, дэмжлэг,

3. Төрийн байгууллагуудын “ЭЙБЛ” программ ашиглалтын зардал, аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимын тоног, төхөөрөмж,

4. Гадаад, дотоодын зочид төлөөлөгчдийг хүлээн авах, хүндэтгэл үзүүлэх зардал,

5. Гадаад арга хэмжээний зардал

6. Манлайбаатар Дамдинсүрэнгийн мэндэлсний 150 жилийн ой

7. Сумдын цагдаагийн албан хаагчдад шатахууны дэмжлэг

8. Үндэсний аюулгүй байдлыг хангах болон терроризитэй тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөлийн Дорнод аймгийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардал

9. Татвар төлөгчдийн өдрүүдийг зохион байгуулах /аймгийн төв, 13 сумдад/

10. Хууль зүйн үйлчилгээний төлбөр /ИТХ, ЗДТГ/
11. Ахмадын байгууллагын нэгжийн удирдлагыг урамшуулна. /14 сум, Хэрлэн сумын 11 баг/
12. Халуун усны газруудын үйл ажиллагаанд дэмжлэг /Хэрлэн сум/
13. Уламжлалт боловсрол төсөл хэрэгжүүлэх зардал
14. Зөгийчдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт
15. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгааллын хөтөлбөр”-ийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх
16. Орон нутагт нэн дутагдалтай багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудын сургалтын төлбөрт дэмжлэг
17. Улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих бүтээн байгуулалтын ажил /авто зам, инженерийн шугам сүлжээ, барилга байгууламж/ барьж байгуулахад амчлал эзэмшил, өмчлөлийн газар чөлөөлөх, нөхөн олговор олгох ажлыг зохион байгуулах зардал

хаслаа.

- Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлыг бууруулах 1553.8 сая төгрөгийн саналаас “Хэрлэн сумын 2.3 дугаар багт өрхийн эмнэлгийн салбар шинээр барих” 200.0 сая төгрөг, “Хэрлэн сумын 10 дугаар багт ахмад настнуудын чөлөөт цагийн төв барих” 89.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээг хууль. журмын шаардлагад нийцсэн гэж үзэн хэвээр үлдээж, 50.0 сая төгрөгийн “Багш нарын сургалт, дадлагын төв байгуулах”, 110.0 сая төгрөгийн “Сурагчийн автобус” /Хэрлэн, Баян-Уул сум/, 40.0 сая төгрөгийн “Нийтийн орон сууцны барилгын засвар” / Хэрлэн сум 1 дүгээр баг 12 айлын орон сууц/ -ын төсөл, арга хэмжээнүүдийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, 252.0 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээг

1. “Эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд арга хэмжээ” Эхчүүдээ хайрлая хөтөлбөрийн хүрээнд вакцинд хамруулах
2. “Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх /2017-2026 он/
3. “Элэгний В вирусын халдваргүй нярай” төслийг үргэлжлүүлж, дархлал тогтцыг үнэлэх
4. “Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээ” БЗДХалдвараас урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах төсөл
5. “Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээ” Дархлаажуулалтын үйл ажиллагааг өргөжүүлэх, томуугийн вакцинд хамруулах
6. “Халдварт бус өвчнөөс сэргийлэх” төсөл хэрэгжүүлэх
7. “Оюутны эрүүл мэндийг дэмжих /Эрүүл оюутан төсөл/”
8. Хөдөөгийн хүн амд төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчийн тусламж, үйлчилгээг хүргэх “Хөдөлгөөнт эмнэлэг” ажиллуулах
9. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд аймаг, сумын төвийн алслагдсан зарим багуудад эмийн сан ажилуулах

хөрөнгө оруулалтын бус хөтөлбөр арга хэмжээ, 25.0 сая төгрөгийн “Эко ариун цэврийн байгууламж” /Баянтүмэн сум/ -ийн төсөл, арга хэмжээг байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд тус тус шилжүүлж, 787.8 сая төгрөгийн 17 төсөл арга хэмжээг

1. Орон нутгийн өмчийн орон сууцыг шинээр бий болгоход дэмжлэг /Гурванзагал сум/
2. Орон нутгийн өмчийн орон сууц барихад дэмжлэг үзүүлэх
3. БОЭТ-ийн цахилгаан шатны засвар
4. БОЭТ-ийн Амбулаторийн барилга, Сүрьеэгийн тасгийн засвар тохижилт
5. Хэрлэн сумын 2, 3-р багийн төв гудамжны хашаа, гэрэлтүүлэг, барилгын нүүрэн талын фасадын ажлыг эхлүүлэх
6. Хохирогчийг хамгаалах “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн хамгаалах, урьдчилан сэргийлэх, нийгмийн ажил үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх

7. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр”, “Эрүүл эмэгтэй хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх
8. Өсвөр үе залуучуудын эрүүл мэндийг дэмжих төсөл хэрэгжүүлэх /14-17 насны/
9. “Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээ” Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах төсөл
10. “Хавдрын эсрэг хамтдаа” аян, арга хэмжээ зохион байгуулах
11. “Харшлаас сэргийлэх “арга хэмжээ зохион байгуулах
12. Орон нутгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнг өндөр хөгжилтэй улсад суралцахад дэмжлэг үзүүлэх
13. Хөдөө орон нутагт эмнэлгийн ажилтанг тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлэх урамшууллыг үе шаттай олгоно
14. “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх
15. Хэрлэн сум, 11-р баг, 406-р байрны боловсон ариун цэврийн байгууламж
16. Музейн засвар /Гурванзагал сум/
17. Орон нутгийн өмчийг түр хадгалах, хамгаалахад зориулсан хашаа, байрны засвар

хаслаа.

- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлыг бууруулах 135.1 сая төгрөгийн саналаас 106.0 сая төгрөгийн 11 төсөл арга хэмжээг

1. Гол, нуур, рашаан, булаг, усны эх болон газрын доорх усны ордуудын гадаад тэжээгдлийн мужийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах
2. Сумын төвүүдийн ус хангамжийн эх үүсвэрүүдийн чанарын судалгааг хийх
3. Хилийн зурвасын дагуу түймрээс хамгаалах шороон зурвасыг сэргээх зардал
4. Уул уурхайн нөлөөгөөр эвдрэлд орсон газрын судалгаа, ажлын зургийн хамт
5. Аймгийн хэмжээнд уул уурхайн аж ахуйн нэгжийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, газрын хэвлийн нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, ажлын үр дүнд мониторинг хийх
6. Нэг голын хүүхдүүд төслийн хүрээнд бүх сумдын сурагчдын дунд түүх, дүрслэх урлаг, хүрээлэн буй орчин, байгалийн ухааны хичээлүүдээр олимпиад, уралдаан зохион байгуулах.
7. Сумдын Засаг даргын тамгын газар, ИТХ, Байгаль орчны тасаг, экологийн цагдаагийн албан хаагчдад байгаль орчны багц хуулийн сургалт зохион байгуулж гарын авлагаар хангах
8. Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагчдыг давтан сургах, үе шаттайгаар сургалтад хамруулах
9. Байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчлийг бууруулах зорилгоор нэгдсэн хяналт шалгалтыг хууль хяналтын байгууллагуудтай хамтран зохион байгуулах.
10. Covid 19 цар тахлын улмаас үүссэн нөхцөл байдалтай холбогдуулж 90 цагийн теле хичээлийг хөл хорионы үед орон нутгийн телевиз, сошиал медиа ашиглан ЕБС-ын сурагчдад хүргэх
11. Нийтийн эзэмшлийн гудамж, талбай, ногоон бүсэд хөдөлгөөнт эргүүл явуулах

хасаж, бусад эх үүсвэрээс төлөвлөгдсөн хууль, журмын шалгуурт нийцэх төсөл, арга хэмжээг шилжүүлэн орууллаа. Төсвийн урсгал зардал дахь аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг 29.1 сая төгрөгөөр буурууллаа.

Мөн Халхголд шинэ сумын төв байгуулсантай холбогдуулан Сум дундын эмнэлгийн хуучин барилгыг дуудлага худалдаагаар борлуулах тухай Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол гарсныг үндэслэн орон нутгийн өмч борлуулсны орлогын 119.7 сая төгрөгөөр аймгийн төсвийн орлогыг нэмэгдүүллээ.

Дээрх нэмэгдсэн орлого болон хасагдсан төсөл, арга хэмжээтэй холбоотой үүссэн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлын санхүүжилтийн эх үүсвэрт хууль, журамд нийцэх, зураг, төсөв, тооцоо судалгаатай ажлуудыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчид болон аймгийн Засаг даргын саналаар шинээр нэмж орууллаа.

Аудитын дүгнэлттэй уялдуулан бусад хөтөлбөр, төсөл арга хэмжээнээс хасагдсан орон нутгийн төсвийн урсгал зардалтай холбоотой ажлуудыг холбогдох урсгал зардалд шилжүүлж, аймгийн Засаг даргын нөөцийн санг 165.0 сая төгрөг, Халамжийн санг 15.0 сая төгрөг, аймгийн ЗДТГ-ын урсгал зардлыг 8.2 сая төгрөг, Гэрэл сэтгэмж ОНӨҮГ -ын урсгал зардлыг 10.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх өөрчлөлт орууллаа.



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

21000, Чойбалсан, Дорнод аймаг
Утас: 7058-4131, 7058-2203

2020.12.09 № 1/2024
танай -ны № -т

Төсвийн төсөлд оруулсан
өөрчлөлтийн тухай

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.БОЛОРТУУЛ ТАНАА

З.Дамдинмаа:

*Төсвийн төсөлд хийсэн
санал дүгнэлтүүд хавсарган
ирж дүгнээр станцистийн
мөнгө бүртгэл, тайланга.*

Б.Болортуул 2020.12.09

Аймгийн 2021 оны төсвийн төсөлд Төрийн аудитын газраас өгсөн санал дүгнэлтийн дагуу орлого нэмэгдүүлэх 157.1 сая төгрөг, зардал бууруулах 1,423.2 сая төгрөг, төсвийн үр ашгийг сайжруулах 2197,2 сая төгрөгийг төсвийн төсөлд тусгах дараах өөрчлөлтүүдийг орууллаа. Үүнд:

1. Төсвийн орлогыг 37.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналын дагуу Халамжийн сангийн 2020 оны үлдэгдлээс 37.4 сая төгрөгийг 2021 оны төсөвт татан төвлөрүүлэхээр тусгалаа.
2. Төсвийн зардлыг бууруулах 2,658.2 сая төгрөгийн саналын дагуу
 - Орон нутгийн төсвийн урсгал зарлагыг бууруулах 19.9 сая төгрөгийг аймгийн Засаг даргын тамгын газрын зардлаас хаслаа.
 - Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг бууруулах 389.0 сая төгрөгийн саналаас "Зүүн бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын гаражийн өргөтгөл"-ийн 100.0 сая төгрөг, "Манлайбаатар Дамдинсүрэнгийн онголсон газрын баганыг сэргээн засварлах" 15.0 сая төгрөг, "Стандарт хэмжил зүйн хэлтсийн албан хэрэгцээнд тоног төхөөрөмж худалдан авах" 12.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээнүүдийг хасаж, 262.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг аймгийн эдийн засаг, нийгмийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусган хуулийн шаардлагад нийцүүлээ.
 - Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын бус хөтөлбөр арга хэмжээний зардлыг бууруулах 560.4 сая төгрөгийн саналаас батлагдсан хөтөлбөргүй гэж үзэн хасах санал ирүүлсэн нийт 164.0 сая төгрөгийн 6 хөтөлбөр нь

1. "Төрийн албан хаагчийн сургалт, хөгжил хөтөлбөр" 2017 оны 01 дүгээр тогтоол
2. "Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр" аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 78 дугаар тогтоол
3. "Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөр" аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 82 дугаар тогтоол
4. "Англи хэлтэй Дорнодчууд хөтөлбөр" аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 88 дугаар тогтоол
5. "Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр" аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 87 дугаар тогтоол
6. "Ахмадын ачлал хөтөлбөр" аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 83 дугаар тогтоол

04 593

аймгийн ИТХ-ын тогтоолуудаар батлагдсан, мал тооллогын 8.0 сая төгрөгийн 1 арга хэмжээний санхүүжилтийг Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолоор аймгийн Засаг даргад хариуцуулсан байгаа тул тус тус хэвээр үлдээж, 15.0 сая төгрөгийн “Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр” хэрэгжүүлэх зардлыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд, 20.0 сая төгрөгийн “Гамшгийн эрсдэлээс хамгаалах судалгаа хийх” зардлыг орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх ажилд шилжүүлэн хуулийн шаардлагад нийцүүлж, 353.4 сая төгрөгийн 17 төсөл, арга хэмжээг

1. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагаа,
2. Зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх нэг удаагийн тусламж, дэмжлэг,
3. Төрийн байгууллагуудын “ЭЙБЛ” программ ашиглалтын зардал, аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимын тоног, төхөөрөмж,
4. Гадаад, дотоодын зочид төлөөлөгчдийг хүлээн авах, хүндэтгэл үзүүлэх зардал,
5. Гадаад арга хэмжээний зардал
6. Манлайбаатар Дамдинсүрэнгийн мэндэлсний 150 жилийн ой
7. Сумдын цагдаагийн албан хаагчдад шатахууны дэмжлэг
8. Үндэсний аюулгүй байдлыг хангах болон терроризитэй тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөлийн Дорнод аймгийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардал
9. Татвар төлөгчдийн өдрүүдийг зохион байгуулах /аймгийн төв, 13 сумдад/
10. Хууль зүйн үйлчилгээний төлбөр /ИТХ, ЗДТГ/
11. Ахмадын байгууллагын нэгжийн удирдлагыг урамшуулна. /14 сум, Хэрлэн сумын 11 баг/
12. Халуун усны газруудын үйл ажиллагаанд дэмжлэг /Хэрлэн сум/
13. Уламжлалт боловсрол төсөл хэрэгжүүлэх зардал
14. Зөгийчдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт
15. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгааллын хөтөлбөр”-ийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх
16. Орон нутагт нэн дутагдалтай багш- мэргэжлээр суралцаж буй оюутнуудын сургалтын төлбөрт дэмжлэг
17. Улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих бүтээн байгуулалтын ажил /авто зам, инженерийн шугам сүлжээ, барилга байгууламж/ барьж байгуулахад амчлал эзэмшил, өмчлөлийн газар чөлөөлөх, нөхөн олговор олгох ажлыг зохион байгуулах зардал

хаслаа.

- Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлыг бууруулах 1,553.8 сая төгрөгийн саналаас “Хэрлэн сумын 2, 3 дугаар багт өрхийн эмнэлгийн салбар шинээр барих” 200.0 сая төгрөг, “Хэрлэн сумын 10 дугаар багт ахмад настнуудын чөлөөт цагийн төв барих” 89.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээг хууль журмын шаардлагад нийцсэн гэж үзэн хэвээр үлдээж, 50.0 сая төгрөгийн “Багш нарын сургалт, дадлагын төв байгуулах”, 110.0 сая төгрөгийн “Сурагчийн автобус” /Хэрлэн, Баян-Уул сум/, 40.0 сая төгрөгийн “Нийтийн орон сууцны барилгын засвар” / Хэрлэн сум 1 дүгээр баг 12 айлын орон сууц/-ын төсөл, арга хэмжээнүүдийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, 252.0 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээг

1. “Эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд арга хэмжээ” Эхчүүдээ хайрлая хөтөлбөрийн хүрээнд вакцинд хамруулах
2. “Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх /2017-2026 он/
3. “Элэгний В вирусын халдваргүй нярай”-төслийг үргэлжлүүлж, дархлал тогтцыг үнэлэх
4. “Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээ” БЗДХалдвараас урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах төсөл
5. “Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээ” Дархлаажуулалтын үйл ажиллагааг өргөжүүлэх, томуугийн вакцинд хамруулах
6. “Халдварт бус өвчнөөс сэргийлэх” төсөл хэрэгжүүлэх
7. “Оюутны эрүүл мэндийг дэмжих /Эрүүл оюутан төсөл/

8. Хөдөөгийн хүн амд төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчийн тусламж, үйлчилгээг хүргэх "Хөдөлгөөнт эмнэлэг" ажиллуулах
9. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд аймаг, сумын төвийн алслагдсан зарим багуудад эмийн сан ажиллуулах

хөрөнгө оруулалтын бус хөтөлбөр арга хэмжээ, 25.0 сая төгрөгийн "Эко ариун цэврийн байгууламж" /Баянтүмэн сум/-ийн төсөл, арга хэмжээг байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд тус тус шилжүүлж, 787.8 сая төгрөгийн 17 төсөл арга хэмжээг

1. Орон нутгийн өмчийн орон сууцныг шинээр бий болгоход дэмжлэг /Гурванзагал сум/
2. Орон нутгийн өмчийн орон сууц барихад дэмжлэг үзүүлэх
3. БОЭТ-ийн цахилгаан шатны засвар
4. БОЭТ-ийн Амбулаторийн барилга, Сүрьеэгийн тасгийн засвар тохижилт
5. Хэрлэн сумын 2, 3-р багийн төв гудамжны хашаа, гэрэлтүүлэг, барилгын нүүрэн талын фасадын ажлыг эхлүүлэх
6. Хохирогчийг хамгаалах "Нэг цэгийн үйлчилгээний төв"-ийн хамгаалах, урьдчилан сэргийлэх, нийгмийн ажил үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх
7. "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр", "Эрүүл эмэгтэй хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх
8. Өсвөр үе залуучуудын эрүүл мэндийг дэмжих төсөл хэрэгжүүлэх /14-17 насны/
9. "Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээ" Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах төсөл
10. "Хавдрын эсрэг хамтдаа" аян, арга хэмжээ зохион байгуулах
11. "Харшлаас сэргийлэх" арга хэмжээ зохион байгуулах
12. Орон нутгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнг өндөр хөгжилтэй улсад суралцахад дэмжлэг үзүүлэх
13. Хөдөө орон нутагт эмнэлгийн ажилтанг тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлэх урамшууллыг үе шаттай олгоно
14. "Элэг бүтэн Монгол" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх
15. Хэрлэн сум, 11-р баг, 406-р байрны боловсон ариун цэврийн байгууламж
16. Музейн засвар /Гурванзагал сум/
17. Орон нутгийн өмчийг түр хадгалах, хамгаалахад зориулсан хашаа, байрны засвар

хаслаа.

- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлыг бууруулах 135.1 сая төгрөгийн саналаас 106.0 сая төгрөгийн 11 төсөл арга хэмжээг

1. Гол, нуур, рашаан, булаг, усны эх болон газрын доорх усны ордуудын гадаад тэжээгдлийн мужийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах
2. Сумын төвүүдийн ус хангамжийн эх үүсвэрүүдийн чанарын судалгааг хийх
3. Хилийн зурвасын дагуу түймрээс хамгаалах шороон зурвасыг сэргээх зардал
4. Уул уурхайн нөлөөгөөр эвдрэлд орсон газрын судалгаа, ажлын зургийн хамт
5. Аймгийн хэмжээнд уул уурхайн аж ахуйн нэгжийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, газрын хэвлийн нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, ажлын үр дүнд мониторинг хийх
6. Нэг голын хүүхдүүд төслийн хүрээнд бүх сумдын сурагчдын дунд түүх, дүрслэх урлаг, хүрээлэн буй орчин, байгалийн ухааны хичээлүүдээр олимпиад, уралдаан зохион байгуулах.
7. Сумдын Засаг даргын тамгын газар, ИТХ, Байгаль орчны тасаг, экологийн цагдаагийн албан хаагчдад байгаль орчны багц хуулийн сургалт зохион байгуулж гарын авлагаар хангах
8. Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагчдыг давтан сургах, үе шаттайгаар сургалтад хамруулах

9. Байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчлийг бууруулах зорилгоор нэгдсэн хяналт шалгалтыг хууль хяналтын байгууллагуудтай хамтран зохион байгуулах.

10. Covid 19 цар тахлын улмаас үүссэн нөхцөл байдалтай холбогдуулж 90 цагийн теле хичээлийг хөл хорионы үед орон нутгийн телевиз, сошиал медиа ашиглан ЕБС-ын сурагчдад хүргэх

11. Нийтийн эзэмшлийн гудамж, талбай, ногоон бүсэд хөдөлгөөнт эргүүл явуулах

хасаж, бусад эх үүсвэрээс төлөвлөгдсөн хууль, журмын шалгуурт нийцэх төсөл, арга хэмжээг шилжүүлэн орууллаа. Төсвийн урсгал зардал дахь аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг 29.1 сая төгрөгөөр буурууллаа.

Мөн Халхголд шинэ сумын төв байгуулсантай холбогдуулан Сум дундын эмнэлгийн хуучин барилгыг дуудлага худалдаагаар борлуулах тухай иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол гарсныг үндэслэн орон нутгийн өмч борлуулсны орлогын 119.7 сая төгрөгөөр аймгийн төсвийн орлогыг нэмэгдүүллээ.

Дээрх нэмэгдсэн орлого болон хасагдсан төсөл, арга хэмжээтэй холбоотой үүссэн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлын санхүүжилтийн эх үүсвэрт хууль, журамд нийцэх, зураг, төсөв, тооцоо судалгаатай ажлуудыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид болон аймгийн Засаг даргын саналаар шинээр нэмж орууллаа.

Аудитын дүгнэлттэй уялдуулан бусад хөтөлбөр, төсөл арга хэмжээнээс хасагдсан орон нутгийн төсвийн урсгал зардалтай холбоотой ажлуудыг холбогдох урсгал зардалд шилжүүлж, аймгийн Засаг даргын нөөцийн санг 165.0 сая төгрөг, Халамжийн санг 15.0 сая төгрөг, аймгийн ЗДТГ-ын урсгал зардлыг 8.2 сая төгрөг, Гэрэл сэтгэмж ОНӨҮГ-ын урсгал зардлыг 10.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх өөрчлөлт орууллаа.

ДАРГА



М.ЭНХТӨР